

## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Тогтвортой амьжиргаа-3 төслийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2023/70/НА-СТА-ТХН

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)  
Улаанбаатар хот  
2023 он

Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг  
Утас: 261665 Цахим хаяг: [naranchimegts@audit.gov.mn](mailto:naranchimegts@audit.gov.mn)

Аудитын менежер: П.Чанцалдулам  
Утас: 261885 Цахим хаяг: [chantsaldulamp@audit.gov.mn](mailto:chantsaldulamp@audit.gov.mn)

Ахлах аудитор: Э.Энхбаатар  
Утас: 261628 Цахим хаяг: [Enkhbaatare@audit.gov.mn](mailto:Enkhbaatare@audit.gov.mn)

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Грант Торнтон аудит ХХК  
Захирал: Б.Осоргарав  
Утас: 70110744 Цахим хаяг: [osorgarav.b@mn.gt.com](mailto:osorgarav.b@mn.gt.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

2023.02.20 № 07/349  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Тогтвортой амьжиргаа-3 төслийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Тогтвортой амьжиргаа-3 төслийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Тогтвортой амьжиргаа-3 төсөл нь үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу 330 сумдын жилийн гүйцэтгэлийн үнэлгээг хөндлөнгийн 3 компани үнэлж, дундаж үнэлгээ 67.71%-иар тогтоож 6,999,890.4 мянган төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангийн урамшуулалд олгосон байна. Сумдад олгох урамшууллыг тооцох суурь үнэлгээний дүнг Монгол улсын Засгийн газрын 2017 оны 230 дугаар тогтоолоор баталсан Орон нутгийн шилжүүлгийг тооцох аргачлалын дагуу Сангийн яам тооцож тогтоож өгдөг байна.

Төслийн үндсэн 3 бүрэлдэхүүн ажлын хүрээнд хийхээр тайлант онд төлөвлөсөн 37 үйл ажиллагаанаас “Төрийн хэмнэлтийн тухай хууль” хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Төрийн албан хаагчид болон иргэдэд зориулсан ОНХС-ийн журмын талаарх хэвлэлийн материал хэвлэх, үндэсний болон орон нутгийн түвшинд ОНХС, Малын тоо толгойн албан татвар, Удирдлагын мэдээллийн сан болон гар утасны аппликейшний талаарх богино хэмжээний видео болон хөтөлбөр бэлтгэж түгээх, Төсөл хэрэгжүүлэх нэгжийн тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх, Цахим бие даан суралцах сургалтын платформын сайжруулалт хийх ажлуудыг хэрэгжүүлэх боломжгүй болсон байна.

## **Аудитын гол асуудал**

Бидний мэргэжлийн үнэлэмжээр аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлууд юм. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлт гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн тусдаа дүгнэлт гаргаагүй болно.

Төслийн хөгжлийн зорилтын шалгуур үзүүлэлт болон дунд шатны шалгуур үзүүлэлт нийт 10 зорилттой. Тайлант хугацаанд төслийн дунд хугацааны үнэлгээгээр төслийн шалгуур үзүүлэлтийн ахицыг хэмжсэний дагуу төслийн нийт 10 шалгуур үзүүлэлтийн 8 нь өссөн 4 үзүүлэлт 100% биелсэн, 4 үзүүлэлт 90%-аас дээш биелсэн, 1 үзүүлэлт бага өсөлттэй, 1 үзүүлэлт буурсан дүнтэй байна.

Буурсан 1 үзүүлэлт нь сумын Орон нутгийн хөгжлийн сангийн төсвийн хэмжээг ойролцоогоор мэдэж байгаа багийн иргэдийн нийт хувь хэмжээ зорилтот түвшин 10% биелэлт удаашралтай гэсэн асуудлыг гол асуудалд оруулж, Төслийн удирдах хороог анхаарлаа хандуулах нь зүйтэй гэж үзсэн.

## **Бусад асуудлын хэсэг**

Монгол Улс, Олон Улсын Хөгжлийн Ассоциаци хоорондын 2014 оны 5 дугаар сарын 5-ны өдрийн 5487 тоот 24,800,000 ам.долларын санхүүжилтийн хэлэлцээрийн дагуу ТХН-ийн хугацааг 2018 оны 12 дугаар сарын 31-нд дуусахаар байсан хэдий ч төслийн үндсэн зорилгын гүйцэтгэл нэмэлт санхүүжилтийн (SLP3) 6588 тоот санхүүжилтийн зээлээр 12,000,000 ам доллар, Швейцарийн хөгжлийн агентлагийн Итгэлцлийн сангийн буцалтгүй тусламжийн санхүүжилтээр 5,665,000 ам.доллар нийт төслийн санхүүжилт 42,465,000 ам.доллар болж өссөн бөгөөд төслийн хаалтын хугацааг 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл сунгасан байна.

Тогтвортой амьжиргаа төсөл нь Дэлхийн банкнаас баталж гаргасан “Санхүүгийн удирдах гарын авлага”-д заасан нягтлан бодох бүртгэлийн мөнгөн суурийн дагуу бэлтгэсэн санхүүгийн тайланг Дэлхийн банканд хүргүүлдэг бол Төсвийн гүйцэтгэлийн тайланг Сангийн сайдын 2007 оны 326 дугаар тушаалаар батлагдсан “Засгийн Газрын шугамаар авч, ашиглаж буй хөнгөлөлттэй зээл болон буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөр, Засгийн Газрын тусгай санд мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, санхүүгийн тайлан, тодруулгын маягтууд, санхүүгийн тайланг бэлтгэж гаргах аргачлал”, УСНББОС 1-ийн дагуу аккруэл сууриар илэрхийлэн бэлтгэн хүргүүлдэг байна.

## **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *B. M.* Ц.НАРАНЧИМЭГ



## Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	167,009,546.65	4,330,990,647.27
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	161,311,466.65	4,330,990,647.27
311	Кассад байгаа бэлэн мөнгө	-	1,635,408.48
31110	Төгрөг	-	1,635,408.48
312	Банканд байгаа бэлэн мөнгө	161,311,466.65	4,329,355,238.79
31210	Төгрөг	161,311,466.65	933,187,658.18
31211	Төрийн санд байгаа бэлэн мөнгө	159,053,522.16	913,214,358.18
31213	Арилжааны банканд байгаа бэлэн мөнгө	2,257,944.49	19,973,300.00
3122	Гадаад валют	-	3,396,167,580.61
31223	Арилжааны банканд байгаа бэлэн мөнгө	-	3,396,167,580.61
33	АВЛАГА	5,698,080.00	-
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	5,698,080.00	-
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	113,379,946.14	284,183,230.16
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	113,379,946.14	284,183,230.16
39200	Биет хөрөнгө	113,379,946.14	284,183,230.16
39203	Авто - тээврийн хэрэгсэл	162,300,000.00	402,509,999.96
39203	Хуримтлагдсан элэгдэл	(134,836,111.09)	(164,460,555.53)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	237,097,235.46	237,097,235.46
39206	Хуримтлагдсан элэгдэл	(198,029,240.05)	(228,520,046.10)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	92,114,654.54	92,114,654.55
39208	Хуримтлагдсан элэгдэл	(45,266,592.72)	(54,558,058.18)
39300	Биет бус хөрөнгө	-	-
39301	Программ хангамж	6,300,000.00	6,300,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(6,300,000.00)	(6,300,000.00)
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>280,389,492.79</b>	<b>4,615,173,877.43</b>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	312,725,370.72	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	312,725,370.72	-
41300	Өглөг	-	-
4136	Бусад өглөг	312,725,370.72	-
41361	Байгууллагад төлөх өглөг	307,027,290.72	-
41363	Татварын өглөг	5,698,080.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	(32,335,877.93)	4,615,173,877.43
511	Засгийн газрын хувь оролцоо	(32,335,877.93)	4,615,173,877.43
512	Хуримтлагдсан үр дүн	(51,196,989.09)	4,615,173,877.43
51210	Өмнөх үеийн үр дүн	1,208,591,417.57	(32,335,877.93)
51220	Тайлант үеийн үр дүн	(1,259,788,406.66)	4,647,509,755.36
51500	Бодлогын өөрчлөлт алдааны залруулга	18,861,111.16	-
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>280,389,492.79</b>	<b>4,615,173,877.43</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН</b>	<b>10,772,900,221.98</b>	<b>13,423,245,999.96</b>
12	ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	10,772,900,221.98	13,183,036,000.00
122002	Тусламжийн санхүүжилт	-	-
141001	Зээлийн санхүүжилт	10,772,900,221.98	13,183,036,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	240,209,999.96
1200045	Үнэ төлбөргүй орлого	-	240,209,999.96
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>12,032,862,951.77</b>	<b>9,547,824,963.21</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	12,032,862,951.77	9,547,824,963.21
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,953,656,951.77	2,547,934,025.57
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	639,971,788.31	733,727,732.17
210101	Үндсэн цалин	639,971,788.31	733,727,732.17
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	84,497,707.89	90,296,248.30
210202	Нийгмийн даатгалын шимтгэл	84,497,707.89	90,296,248.30
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	41,250,000.00	37,800,000.00
210304	Байрны түрээс	41,250,000.00	37,800,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	22,289,799.30	10,875,454.39
210401	Бичиг хэрэг	545,223.54	368,727.27
210402	Тээвэр, шатахуун	4,060,000.00	2,546,536.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,354,127.88	5,810,585.85
210404	Ном хэвлэл	6,218,694.54	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх,	5,111,753.34	2,149,605.27
2107	Томилолт, зочны зардал	-	67,182,876.86
210702	Дотоод албан томилолт	-	67,182,876.86
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,091,110,185.10	897,811,007.77
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,091,110,185.10	897,811,007.77
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	74,537,471.17	710,240,706.08
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага	-	640,833,990.14
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	74,537,471.17	69,406,715.94
2131	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,079,206,000.00	6,999,890,937.64
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	9,079,206,000.00	6,999,890,937.64
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН</b>	<b>(1,259,962,729.79)</b>	<b>3,875,421,036.75</b>
<b>145</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН</b>	<b>174,323.13</b>	<b>772,088,718.61</b>
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	174,323.13	772,088,718.61
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН</b>	<b>(1,259,788,406.66)</b>	<b>4,647,509,755.36</b>

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	-	-	<b>1,227,452,528.73</b>	<b>1,227,452,528.73</b>
Тайлант үеийн үр дүн	-	-	(1,259,788,406.66)	(1,259,788,406.66)
<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	-	-	<b>(32,335,877.93)</b>	<b>(32,335,877.93)</b>
Тайлант үеийн үр дүн	-	-	4,647,509,755.36	4,647,509,755.36
<b>2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	-	-	<b>4,615,173,877.43</b>	<b>4,615,173,877.43</b>

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН</b>	<b>10,772,900,221.98</b>	<b>13,183,036,000.00</b>
12	ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	10,772,900,221.98	13,183,036,000.00
141001	Зээлийн санхүүжилт	10,772,900,221.98	13,183,036,000.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>11,792,584,026.06</b>	<b>9,785,445,537.99</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	11,792,584,026.06	9,785,445,537.99
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	11,792,584,026.06	2,785,554,600.35
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	639,971,788.31	733,727,732.17
210101	Үндсэн цалин	639,971,788.31	733,727,732.17
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	84,497,707.89	90,296,248.30
210201	Нийгмийн даатгалын шимтгэл	84,497,707.89	90,296,248.30
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	41,250,000.00	37,800,000.00
210304	Байрны түрээс	41,250,000.00	37,800,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	22,289,799.30	10,875,454.39
210401	Бичиг хэрэг	545,223.54	368,727.27
210402	Тээвэр, шатахуун	4,060,000.00	2,546,536.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,354,127.88	5,810,585.85
210404	Ном, хэвлэл	6,218,694.54	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх,	5,111,753.34	2,149,605.27
2107	Томилолт, зочны зардал	-	67,182,876.86
210702	Дотоод албан томилолт	-	67,182,876.86
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,925,368,730.56	1,204,838,298.49
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,925,368,730.56	1,190,962,829.06
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	13,636,363.64
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	-	239,105.79
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	640,833,990.14
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	640,833,990.14
2131	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,079,206,000.00	6,999,890,937.64
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	9,079,206,000.00	6,999,890,937.64
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>(1,019,683,804.08)</b>	<b>3,397,590,462.01</b>
14	БУСАД ЭХ ҮҮСВЭР	174,323.13	772,088,718.61
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	174,323.13	772,088,718.61
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>174,323.13</b>	<b>772,088,718.61</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>(1,019,509,480.95)</b>	<b>4,169,679,180.62</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>1,180,820,947.60</b>	<b>161,311,466.65</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>161,311,466.65</b>	<b>4,330,990,647.27</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>9,853,906,200.00</b>	<b>9,785,445,538.00</b>	<b>68,460,662.00</b>	<b>99.3</b>
УРСГАЛ ЗАРДАЛ	9,853,906,200.00	9,785,445,538.00	68,460,662.00	99.3
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,854,015,200.00	2,785,554,600.35	68,460,599.65	97.6
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	736,621,000.00	733,727,732.17	2,893,267.83	99.6
Үндсэн цалин	736,621,000.00	733,727,732.17	2,893,267.83	99.6
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	91,725,200.00	90,296,248.30	1,428,951.70	98.4
Тэтгэврийн даатгал	91,725,200.00	90,296,248.30	1,428,951.70	98.4
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	37,800,000.00	37,800,000.00	-	100.0
Байрны түрээс	37,800,000.00	37,800,000.00	-	100.0
Хангамж, бараа материалын зардал	12,106,400.00	10,875,454.39	1,230,945.61	89.8
Бичиг хэрэг	341,000.00	368,727.27	(27,727.27)	108.1
Тээвэр, шатахуун	2,739,900.00	2,546,536.00	193,364.00	92.9
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,551,800.00	5,810,585.85	741,214.15	88.7
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,473,700.00	2,149,605.27	324,094.73	86.9
Томилолт, зочны зардал	73,971,200.00	67,182,876.86	6,788,323.14	90.8
Дотоод албан томилолт	73,971,200.00	67,182,876.86	6,788,323.14	90.8
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,231,110,000.00	1,204,838,298.49	26,271,701.51	97.9
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,217,200,000.00	1,190,962,829.06	26,237,170.94	97.9
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	13,910,000.00	13,636,363.64	273,636.36	98.0
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	-	239,105.79	(239,105.79)	-
Бараа үйлчилгээний бусад зардал	670,681,400.00	640,833,990.14	29,847,409.86	95.6
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	670,681,400.00	640,833,990.14	29,847,409.86	95.6
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,999,891,000.00	6,999,890,937.64	62.36	100.0
Засгийн газрын урсгал шилжүүлэг	6,999,891,000.00	6,999,890,937.64	62.36	100.0
Засгийн газрын дотоод шилжүүлэг	6,999,891,000.00	6,999,890,937.64	62.36	100.0
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>9,853,906,200.00</b>	<b>13,183,036,000.00</b>	<b>(3,329,129,800.00)</b>	<b>133.7</b>
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	9,853,906,200.00	13,183,036,000.00	(3,329,129,800.00)	133.7
Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	9,853,906,200.00	13,183,036,000.00	(3,329,129,800.00)	133.7
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	161,311,466.65	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	4,330,990,647.27	-	-
Төсвийн гүйцэтгэлийн тохируулгын өөрчлөлт		772,088,718.61		-

**Гурав. Аудитын илрүүлэлт:**

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 130,253.5 мянган төгрөгийн 4 алдаа илэрснээс 1 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 130,253.5 мянган төгрөгийн алдаа, зөрчлийг дахин давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өгөв.

**3.1 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/									
			Үүнээс									
	Төлбөрийн акт	Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал				
Тоо		Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
"Малын тоо толгойн албан татварыг хэрэгжүүлэх гарын авлага боловсруулах" бие даасан зөвлөхийн ажилд 28,676.9 мянган төгрөгийн гэрээ байгуулж, гэрээний урьдчилгаанд 5,735.8 мянган төгрөг олгосон бөгөөд гэрээний хугацааг сунгаж, 2022 оны 8 сард дууссан боловч тайлант оны эцэст энэхүү ажил дуусаагүй 2023 онд үргэлжлэхээр болсон байна.	1						1					
Тайлант онд тээврийн хэрэгсэл нь 9,264 км-ыг орон нутгийн томилолт болон хот доторх ажилд зарцуулсан ба жолоочийн замын хуудсанд спидометрийн заалтын эхний болон эцсийн заалтыг хөтлөөгүй, зөвхөн явсан км-ээр тооцож 5,292.0 мянган төгрөгийн шатахууны мөнгийг олгосон, төслийн машин тухайн төсөлдөө 100 хувь ашиглагдаж байгаа эсэхийг тодорхойлох, шатахууны хэтрэлт хэмнэлтийг хянах боломжгүй байна.	1	5,292.0					1	5,292.0				
Төсөл хэрэгжүүлэх нэгж нь Ниссан патрол, Лексүс 470, Ландкрузэр 200 маркийн 3 автомашинтай ба 1 автомашин нь баруун таван аймгийн хэрэгцээнд, 2 автомашин Төсөл хэрэгжүүлэх нэгжийн үйл ажиллагаанд ашиглагддаг байна. Тайлант оны сүүлийн хагаст Төсөл хэрэгжүүлэх нэгжийн ашигладаг автомашин ашиглалтгүй байсаар байтал автомашин зайлшгүй шаардлагатай эсэхийг үнэлээгүй, ашиглалтгүй үеийн жолоочийн цалинг бүтэн олгосон мөн тээврийн хэрэгслийг Засгийн газрын авто баазад шилжүүлэх эсэхийг шийдээгүй байна.	1				1							

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн тайланд татварын авлага, өглөгийн үлдэгдэлгүй гэж тайлагнасан боловч татварын цахим системийн тодорхойлолтоор ХХОАТ болон тээврийн хэрэгслийн татвартай холбоотой 121,408.6 мянган төгрөгийн илүү төлөлт, 3,552.9 мянган төгрөгийн дутуу төлөлттэй, өнөөдрийг хүртэл энэхүү зөрүүний шалтгааныг тогтоож, татварын албатай тооцоо нийлээгүй байна.	1	124,961.5					1	124,961.5				
<b>Дүн</b>	<b>4</b>	<b>130,253.5</b>					<b>1</b>		<b>3</b>	<b>130,253.5</b>		

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар 1 зөрчил<sup>1</sup> илэрснээс шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах зөвлөмж өгсөн.

### 3.2 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Шилэн дансны цахим хуудсанд мэдээлбэл зохих 121 мэдээллээс 2 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байна.	1						1		-			
<b>Дүн</b>	<b>1</b>						<b>1</b>		<b>-</b>			

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.